МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ “УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ "УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.06.30 Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан журмын "Хяналт-шинжилгээний арга зүй" болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцох аргачлалыг ашиглан хувиар илэрхийлсэн болно. Аргачлалд ашиглагдсан томьёог зургаар оруулав.

*Зураг 1:*

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 35 дугээр тогтоолын *1 дүгээр хавсралт*аар Монгол Улсын хэмжээнд тэргүүлэх 4 чиглэлийг тодорхойлсон.

*Тэргүүлэх чиглэлийн биелэлт:*

Дээрх 4 тэргүүлэх чиглэлийн эдийн засгийн бодлого болон хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 2 тэргүүлэх чиглэлд нийт 4 зорилго, 13 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

1.3-т Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, 1.3.2-т Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх гэж, 1.3.2.6-д Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан хүний оролцоо, хүнд суртлыг арилгах гэж 1 зорилт хийхээр тусгажээ.

1.5-д Шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх хэсэгт 1.5.2-т Хиймэл оюун ухаан, мэдээллийн технологийн үндэсний дэд бүтцийг хөгжүүлж, дижитал шилжилтийг эрчимжүүлэх зорилгын хүрээнд:

1.5.2.1-т Үндэсний хиймэл дагуул бүтээх, хөөргөх бэлтгэл ажлыг хангах;

1.5.2.2. Нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;

1.5.2.3. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын газрын станц байгуулах;

1.5.2.4. Дрон ашиглалтын талаарх эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах ажлыг эхлүүлэх;

1.5.2.5. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах ажлыг эхлүүлэх;

1.5.2.6. Шинжлэх ухааны виртуал парк байгуулах төслийг хэрэгжүүлэх;

1.5.2.7. Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, газар зүйн мэдээллийн систем, блокчэйн технологийг ашиглан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, хөгжлийн бодлого боловсруулах орон зайн цахим дэд бүтцийг байгуулах;

1.5.2.8. Олон улсын цахим төлбөрийн системийг өргөжүүлж, төлбөр тооцоог хүлээн авах, цахим худалдааны арга хэлбэрийг нэмэгдүүлэх гэсэн 8 зорилт тавьсан байна.

4.1-д "Төрийн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглаж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгох /Ухаалаг "E-Mongolia", AI шинэчлэл-Цахим засаглал/" зорилгын хүрээнд:

4.1.2. Аж үйлдвэрийн IV хувьсгалын технологиудыг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд нэвтрүүлэх цахим шилжилтийг үргэлжлүүлж, суурь судалгааны ажлуудыг санхүүжүүлж, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлэх /Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, блокчэйн, ухаалаг бот, IoT/;

4.1.3. Төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэг загвар бүхий нэгдсэн удирдлагатай болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн платформ "E-Mongolia"-тай холбох;

4.1.7. Аливаа контентын жинхэнэ, эсхүл хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн эсэхийг тодорхойлох, байгууллагын болон иргэдийн нэр хүндэд халдах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийг бий болгох 3 зорилтыг дэвшүүлсэн байна.

4.7-д Орчны аюулгүй байдлыг хангаж, хүн, нийгмийн амар тайван орчныг бий болгох зорилгын хүрээнд 4.7.12-т Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх 1 зорилтыг тус тус дэвшүүлжээ.

Дээрх тэргүүлэх чиглэлүүдээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар ахицтай хэрэгжсэн хэд хэдэн зорилт байна. Тодруулбал:

1.3.2.6. Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан хүний оролцоо, хүнд суртлыг арилгах зорилтын биелэлтийг "Зөвшөөрлийн тухай хуулиар батлагдсан 178 тусгай зөвшөөрөл, 66 энгийн зөвшөөрөл нийт 244 зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем "e-Mongolia"-ийн дэд-суваг болох "e-business.mn"-д нэгтгэсэн. https://e-business.mn/home" гэж тайлагнасан байна.

Мөн 1.5.2.8. Олон улсын цахим төлбөрийн системийг өргөжүүлж, төлбөр тооцоог хүлээн авах, цахим худалдааны арга хэлбэрийг нэмэгдүүлэх зорилтын биелэлтийг "Олон улсын стандарт, шаардлагыг хангасан төлбөрийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Монголбанк, Голомт банк,

Худалдаа хөгжлийн банктай Apple компанийн "Apple Pay" үйлчилгээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нэвтрүүлсэн.

"Apple Pay" үйлчилгээ нь IOS үйлдлийн систем бүхий Apple компанийн ухаалаг гар утас, ухаалаг цаг зэрэг бүтээгдэхүүнийг ашиглан хэрэглэгчдэд төлбөр хийх боломжийг олгодог.

Энэхүү үйлчилгээ нэвтэрснээр үндэсний төлбөрийн "₮ карт"-ыг ашиглан олон улсад төлбөр тооцоо хийх нөхцөл бүрдсэн. Мөн манай улсын иргэдэд олон улсын төлбөр тооцооны шинэ гарцыг нээсэн чухал алхам болсон. Монгол Улсад ашиглагдаж буй 150 гаруй мянган ПОС төхөөрөмжүүдэд iPhone утсаа ашиглан төлбөр тооцоо хийх боломж бий болсон. Дэлхийн хаанаас ч Монгол Улсын 1,600,000 гаруй IOS хэрэглэгчдэд iPhone, Apple Watch, Mac болон iPad гар утсаа ашиглан худалдан авалт хийх нөхцөл бүрдсэн. Мөн хил дамнасан онлайн худалдааг дэмжих зорилгоор БНХАУ-ын TEMU онлайн худалдааны платформын Монгол Улс дахь төлөөлөгчөөр шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч "MN Post" сонгогдон үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна. Тус онлайн худалдааны платформын Монгол Улс дахь хүргэлт, тээвэрлэлтийг "Монгол шуудан", "UBCab Express" компаниуд хариуцан ажиллаж байна." гэж тус тус тайлагнасан тул тус зорилтууд үр дүнтэй хэрэгжиж байна гэж үзлээ.

Түүнчлэн дээрх тэргүүлэх чиглэлд туссан хэд хэдэн амжилтгүй буюу ажиллагаа хийгдээгүй зорилтууд байгааг үүгээр онцолж байна. Үүнд:

1.5.2.6. Шинжлэх ухааны виртуал парк байгуулах төслийг хэрэгжүүлэх зорилтын биелэлтийн хувьд "Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төсөл гүйцэтгэх" ажлыг хийж байна. Монгол Улсын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцэх хувилбаруудыг гаргах зорилгоор Matching fund буюу төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн загвар зэрэг боломжит хувилбаруудыг судалж, тэдгээрийн давуу тал, сул тал, хэрэгжих боломжийг шинжилсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн, цаашид хэрэгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулна. Мөн Япон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран Startup Ecosystem судалгааг хэрэгжүүлж байна" гэж тайлагнасан буюу шинжлэх ухааны виртуал парк байгуулах төслийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжиж байна гэж үзлээ.

Мөн 1.5.2.7. Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, газар зүйн мэдээллийн систем, блокчэйн технологийг ашиглан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, хөгжлийн бодлого боловсруулах орон зайн цахим дэд бүтцийг байгуулах зорилтын биелэлтийг "Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Мөн их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн. Дээрх суурь судалгаанд үндэслэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг төслийг 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан, стратегийн төслийн талаарх танилцуулгыг нийт 8 удаагийн хэлэлцүүлэгт танилцуулан хэлэлцүүлсэн. Үүний дараагаар Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, газар зүйн мэдээллийн систем, блокчэйн технологийг ашиглан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, хөгжлийн бодлого боловсруулах орон зайн цахим дэд бүтцийг байгуулах ажиллагаа хийгдэнэ" гэж

тайлагнасан байдлаас үзвэл уг зорилтыг хэрэгжүүлэх ажиллагаа суурь шатанд хэрэгжиж байх тул үр дүнгүй гэж үзлээ.

Түүнчлэн 4.1.7. Аливаа контентын жинхэнэ, эсхүл хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн эсэхийг тодорхойлох, байгууллагын болон иргэдийн нэр хүндэд халдах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийг бий болгох зорилтын биелэлтийг "Аливаа контентын жинхэнэ, эсхүл хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн эсэхийг тодорхойлох, байгууллагын болон иргэдийн нэр хүндэд халдах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна" гэж тайлагнасан бөгөөд нотлох баримт оруулаагүй байгаа зэргээс үзэж үр дүнгүй гэж үзэж 0 хувиар үнэлгээ хийгдлээ.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд нийт 13 зорилтын 13 арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд тайлагнал ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дунджаар 43.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь тус чиглэлийн хэрэгжилтийн явц хангалтгүй түвшинд байгаа бөгөөд дараах байдлаар ангилсан үзүүлэлттэй байна:

1. "Үр дүн гарсан" буюу зорилтот түвшний 85-100 хувийн гүйцэтгэлтэй – 2 арга хэмжээ (15.4%)
2. "Үр дүн хүлээгдэж байгаа" буюу 60-84 хувийн гүйцэтгэлтэй – 1 арга хэмжээ (7.7%)
3. "Үр дүн хангалтгүй" буюу 30-59 хувийн гүйцэтгэлтэй – 7 арга хэмжээ (53.8%)
4. "Үр дүн гараагүй" буюу 0-29 хувийн гүйцэтгэлтэй – 3 арга хэмжээ (23.1%)

Эдгээр дүнгээс харахад хэрэгжилтийн ихэнх хувь нь 60 хувиас доош үзүүлэлттэй, цөөн тооны арга хэмжээ зорилтот түвшинд хүрсэн байдалтай байна. Энэ нь бодлогын хэрэгжилтийн үр дүнг хангалтгүй гэж дүгнэх үндэслэл болж байна.

Тайлагнасан 13 арга хэмжээнээс:

5 арга хэмжээ (38.5%) нь ажлын даалгавар боловсруулах, судалгаа хийх, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, тендерийн баримт бичиг, үнэлгээний хороо байгуулах, гэрээ байгуулах бэлтгэл хангах зэргээр анхан шатны бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжиж байна.

8 арга хэмжээ (61.5%) нь нэвтрүүлэлт хийж эхэлсэн, систем хөгжүүлэлт хийгдэж буй, бодлого, эрх зүйн орчны судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулагдсан, үндэсний хэмжээний уулзалт, чуулга уулзалт хийж, хэрэгжилтийн эхлэл тавигдсан гэх зэргээр тодорхой хэрэгжилтийн шатанд явж байна.

Хэдий тийм боловч дээрх ажлуудын дийлэнх нь төслийн анхан шатны бэлтгэл, суурь судалгааны үе шаттай уялдан гүйцэтгэлийн хувь бага байгаа нь зорилтот түвшинг хангах нөхцөл хараахан бүрдээгүй байгааг харуулж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 35 дугаар тогтоолын <u>*2 дугаар хавсралт*</u>аар баталсан төлөвлөгөөнд тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх 11 төсөл арга хэмжээ тусгагджээ. Үүнд:

4-т <u>"Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого"</u>-ын 4.1-д "Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх" гэж, 4.1.2-д "Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулах" гэж тус тус тусгаж дээрх дэд зорилтуудын хүрээнд 10 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгджээ. Үүнд:

4.1.2.1. Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах;

4.1.2.2. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх;

4.1.2.3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмжийг шинэчлэх /Улсын хэмжээнд/;

4.1.2.4. Харилцаа холбооны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.1.2.5. Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх;

4.1.2.6. Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх;

4.1.2.7. "Ухаалаг засаг II" төслийг хэрэгжүүлэх;

4.1.2.8. "Хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр" төсөл хэрэгжүүлэх;

4.1.2.9. Мэдээлэл технологийн хаб байгуулах;

4.1.2.10. Сэлгэн ажиллах дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгох гэж тус тус төлөвлөсөн байна.

Мөн "4.6. Орчны аюулгүй байдлыг хангах" зорилтын 4.6.3-д "Хүн, нийгмийн амар тайван байдлыг хангах" дэд зорилтын хүрээнд 4.6.3.2. Кибер аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлэх нэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого хэсгийн 4.1-д "Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх" малгай зорилтын хүрээнд тус яам "Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулах" дэд зорилгыг дэвшүүлж энэ хүрээнд гүйцэтгэхээр тусгасан 10 зорилтыг дараах байдлаар тайлагнан ирүүлжээ. Үүнд:

4.1.2.7. "Ухаалаг засаг II" төслийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд "Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний үр ашиг, хэрэглээг сайжруулах, дижитал ур чадварыг дээшлүүлэх, дижитал технологид суурилсан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд үндсэн 3 зорилтын хүрээнд 18 төслийн гэрээг байгуулан хэрэгжүүлж, 8 төсөл худалдан авах ажиллагааны шатанд, 12 төслийн ажлын даалгаврыг боловсруулан ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, төслийн үр шим хүртэгч байгууллага Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Авлигатай тэмцэх газартай хамтран төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна" гэж тайлагнасан байх бөгөөд ажлын гүйцэтгэлийг хувиар илэрхийлэх шалгуур үзүүлэлт тавьж зорилтот түвшнийг 15 хувьд хүргэхээр тооцсон байх бөгөөд хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 13 хувьтай гүйцэтгэж байгаагаар тайлагнасан байдлаас үзвэл төслийн хэрэгжилтийг 2025 онд 15 хувьд хүргэх зорилт амжилттай хэрэгжиж байна гэж үзлээ.

Мөн түүнчлэн 4.1.2.8. "Хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр" төсөл хэрэгжүүлэх зорилгын биелэлтийг "Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Мөн их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн. Дээрх суурь судалгаанд үндэслэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг төслийг 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан, стратегийн төслийн талаарх танилцуулгыг нийт 8 удаагийн хэлэлцүүлэгт танилцуулан хэлэлцүүлсэн" гэж тайлагнасан байх ба шалгуур үзүүлэлтийг төслийн хэрэгжилтээр тооцож хэмжих нэгжийг хувиар

илэрхийлэн, 2025 оны эцэст 100 хувь хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн байх бөгөөд хүрсэн түвшнийг 70 хувьтай гэж үзсэн байна.

4.6.3.2. Кибер аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгын хүрээнд "Монгол Улс дахь Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний судалгааг Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага буюу ЖАЙКА болон дэлхийн кибер аюулгүй байдлын чадавхын төвтэй хамтран гаргасан бөгөөд судалгааны эцсийн тайланг 2025 оны 02 сард хүлээн авсан. Судалгааг - Кибер аюулгүй байдлын бодлого болон стратеги - Кибер аюулгүй байдлын соёл болон нийгэм - Кибер аюулгүй байдлын мэдлэг болон чадамж - Хууль эрх зүй болон зохицуулалтын орчин - Стандарт болон технологи гэсэн ерөнхий 5 агуулгын хүрээнд гаргаж, Монгол Улс Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний судалгаагаар эхлэл түвшнээс хөгжиж буй түвшинд гэж гарсан байна. ЦХИХХЯамнаас Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний судалгааны танилцуулга хурлыг Английн Оксфордын их сургуультай хамтран 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Галлериад зохион байгуулж, хурлын панелистаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Мэдээллийн аюулгүй байдлын газар, Монгол Улсын Их сургуулийн төлөөлөл нийт 10 байгууллагын 40 гаруй оролцогч оролцсон. Кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааны танилцуулга хуралд оролцсон төлөөлөгчид болон судалгааны багаас ирүүлсэн асуултуудад ЦХИХХЯамнаас хариулт, тайлбар мэдээллийг өгч ажилласан. Мөн Судалгааны ажлын танилцуулга, зөвлөмжийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны пэйж хуудсаар дамжуулж олон нийтэд нээлттэй ил тод байршуулж танилцуулсан" гэж тайлагнажээ. Түүнчлэн уг зорилгыг хэрэгжүүлсэн эсэхийг хянахад дараах шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тавьсан байна. Үүнд:

| Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Мэдээллийн аюулгүй байдлын талаарх гадаад, дотоод аудитын үнэлгээ /0-9/ | Түвшин | 4.00 | 6 | 0.00 | 0.00% | |
| 2. Кибер аюулгүй байдлыг хангах өнөөгийн түвшинг үнэлэх арга хэмжээний хэрэгжилт | Хувь | | 100 | 100.00 | 100.00% | |

Өөрөөр хэлбэл Мэдээллийн аюулгүй байдлын талаарх гадаад, дотоод аудитын үнэлгээ /0-9/ байх шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгжийг түвшин гэж тогтоож, суурь түвшнийг 4.00 зорилтот түвшнийг 6 байхаар тооцсон боловч, хүрсэн түвшинг 0, гүйцэтгэлийн хувийг 0 гэж тайлагнан аливаа тайлбар оруулаагүй байна.

Мөн Кибер аюулгүй байдлыг хангах өнөөгийн түвшинг үнэлэх арга хэмжээний хэрэгжилтийг хувиар илэрхийлж зорилтот түвшинг 100 хувь байхаар тооцсон байх бөгөөд хүрсэн түвшнийг 100 хувиар, гүйцэтгэлийн хувийг 100-аар илэрхийлсэн байх ба ирүүлсэн тайлан зэргээс шалтгаалан 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлэх ажиллагаагаа бүрэн дуусcан мэтээр тайлагнасан байна.

Түүнчлэн дээрх тэргүүлэх чиглэлд туссан хэд хэдэн зорилт шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг буруу тогтоосны улмаас үнэлгээ буурч байгааг үүгээр онцолж байна. Үүнд:

4.1.2.5. Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгын хүрээнд "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/07 дугаар тушаалаар Иргэдийн амьжиргаа, цаг хугацааг хэмнэх амьдрах таатай орчныг бүрдүүлэх "Дижитал-Аймаг, Дижитал-Хот" бодлогын зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан зөвлөмжийн төслийг боловсруулсан. "Дижитал-Аймаг, Дижитал-Хот" бодлогын зөвлөмжийг 2025 онд Булган, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий гэсэн 7 аймагт хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг 2025 оны 3 дугаар сарын 31-ны өдөр батлан худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 8 өдөр зарлан ажиллаж байна" гэж тайлагнасан боловч, шалгуур үзүүлэлтийг шилжилт хийсэн аймаг

байхаар төлөвлөж 2025 оны сүүлийн улиралд гэхэд өмнөх оны 2 аймгаас гадна дахин 5 аймаг цахим шилжилт хийсэн байхаар төлөвлөсөн боловч суурь ажиллагаа хийгдсэн буюу одоогоор нэмэлтээр цахим шилжилтэд орсон аймаг байхгүй гэж үзэхээр байх тул 0 хувиар үнэлгээ хийгдлээ.

Мөн 4.1.2.6-д Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх зорилтыг тусгаж хэрэгжилтийг “Үндэсний радио давтамжийн хяналтын систем, баталгаажуулалтын лабратори байгуулах төслийн хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2025 оны 4, 5 дугаар сард төсөл хэрэгжүүлэгч CMEC (China machine engineering corporation) компанитай хамтран Улаанбаатар хот, Чингэс хаан нисэх буудал, Эрдэнэт, Дархан, Хөвсгөл, Архангай, Замын үүд, Алтанбулаг, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Увс, Завхан, Ховд, Дорнод зэрэг аймгуудад Радио долгион хяналтын суурин станц суурилуулах газрыг сонгох хэмжилтийн ажлууд хийгдсэн. Газрын зөвшөөрөл авахаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх аймгуудын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлсэн” гэсэн боловч мөн л дээрх зорилттой адил шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хэрэгжилт хангалтгүй байх тул 0 хувиар үнэлгээ хийв.

Түүнчлэн 4.1.2.1. Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах зорилтыг “Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа” ЦХИХХЯ/20250203039 дугаартай төслийн ажлыг даалгавар болон тус тендерийг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороо байгуулах тушаалын төслийг тус тус боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын “Үнэлгээний хороо байгуулж, зардал гаргах тухай” 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаал батлагдсан” гэж тайлагнасан байдлаас үзвэл нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах ажиллагааны суурь тавигдсан байх боловч төслийн хэрэгжилтийг хувиар илэрхийлэхээр зааж 2025 оны сүүлд гэхэд 50 хувьд хүргэхээр тусгасан боловч хүрсэн түвшин хангалтгүй, нотлох баримт ирүүлээгүй гэх мэт асуудлууд байлаа.

Мөн 4.1.2.2. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх зорилгын хувьд “Бүгд найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани ЦХИХХЯ хооронд байгуулах “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” арилжааны гэрээний нөхцөлийг сайжруулах, гэрээний үнийн дүнг буулгах, гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр Талес Алениа Спейс компанитай хамтран ажиллаж байна” гэж тайлагнасан ба 2025 оны сүүлд гэхэд дээрх зорилтоо 50 хувьд хүргэхээр тусгасан боловч гүйцэтгэлийн хувь 10, хүрсэн түвшин 2 гэж тайлагнан, Талес Алениа Спейс компанитай ямар байдлаар хамтран ажиллаж байгаа талаар баримт нотлогоо хавсаргаагүй байх тул журамд заасан аргачлалын дагуу 20 хувиар үнэлгээ хийлээ.

2025 оны Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбарыг дэмжих 11 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс ихэнх нь хэрэгжилтийн эхний шатанд явагдаж байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийн явц харьцангуй удаашралтай, зарим төсөл арга хэмжээ гэрээ байгуулах, зураг төсөв боловсруулах зэрэг бэлтгэл ажлын шатандаа байна. Тодруулбал:

1. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь буюу "*үр дүн хүлээгдэж байгаа*"-1 төсөл арга хэмжээ
2. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу "*үр дүн хангалтгүй*"-2 төсөл арга хэмжээ

3. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь буюу "*үр дүн гараагүй*"-8 төсөл арга хэмжээ байна.

Төсөл, арга хэмжээнүүдийн дундаж гүйцэтгэлийн хувь:

ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж гүйцэтгэл: 21.4%

Хөтөлбөрийн үр дүнгийн дундаж гүйцэтгэл: 21.4%

Үүний зэрэгцээ, дээр дурдсан 11 төсөл, арга хэмжээний дийлэнх нь одоогийн байдлаар анхан шатны бэлтгэл ажил болох ажлын даалгавар боловсруулах, судалгаа хийх, зураг төсөв гаргах, худалдан авах ажиллагаа зарлах, гэрээ байгуулах, байршил сонгох зэрэг төрийн бүтээн байгуулалтын өмнөх шатны үйл ажиллагаанууд үргэлжилж байна. Тухайлбал:

“Цахим шилжилтийг эрчимжүүлэх”, “Мэдээллийн технологийн хаб байгуулах”, “Сэлгэн ажиллах дата төвийн тоног төхөөрөмж” зэрэг төслүүд нь зураг төсөв боловсруулах, техник шаардлага тодорхойлох, тендер шалгаруулах бэлтгэл хангах, байршил тогтоох зэргээр бэлтгэл ажилд анхаарсан шатандаа яваа бөгөөд одоогоор үйлдвэрлэлт, угсралт, хэрэгжилтийн үндсэн үе шат руу шилжиж амжаагүй байна.

Мөн зарим төсөл, жишээлбэл “Хиймэл оюун ухааны үндэсний стратеги” зэрэг нь судалгаанд суурилсан, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах түвшинд байгаагаас харахад төслийн гүйцэтгэл бодит үр өгөөж бий болох шатандаа хараахан хүрээгүй байна.

Эдгээрээс харахад нийт төсөл, арга хэмжээний 63.6% нь анхан шатны бэлтгэл ажил (ажлын даалгавар боловсруулах, зураг төсөв батлах, гэрээ байгуулах гэх мэт)-ын шатанд, үлдсэн 36.4% нь хэрэгжилтийн тодорхой шатанд явж байна. Гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт нь 21.6% байгаа нь төлөвлөсөн зорилтот түвшнээс доогуур бөгөөд хэрэгжилтийг цаашид эрчимжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” 35 дугээр тогтоолын ***3 дугаар хавсралт***аар баталсан "4.1.2. Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулах" зорилтын хүрээнд дараах 5 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж 14 хувьтай байна. Үүнд:

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилтийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шинээр байгуулах сервер | Тоо | 1 | 0.00 | 0.00% | Ажил хэрэгжиж эхлээгүй |
| 2 | Төслийн хэрэгжилт | Хувь | 20 | 2.00 | 10.00% | Стратеги батлагдсаны дараа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн |
| 3 | Арга хэмжээний хэрэгжилт | Хувь | 100 | 0.00 | 0.00% | Хэрэгжилт байхгүй |
| 4 | Үүрэн холбооны сүлжээ нэмэгдэх баг | Тоо | 1,562 | 1,511 00 | 30.00% | Төслүүд хэрэгжиж буй ба зарим нь ашиглалтад ороход бэлэн |
| 5 | Сэлгэн ажиллах дэд төв | Тоо | 1 | 0.30 | 30.00% | Тендерийн гэрээ байгуулсан, хэрэгжилт явагдаж байна |

## Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 1,2 дугаар хавсралтын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд дараах дүгнэлтийг гаргав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар тэргүүлэх чиглэлүүдийн зарим зорилт үр дүнтэй хэрэгжсэн хэдий ч, зарим зорилт, шалгуур үзүүлэлтийн тодорхойгүй байдал, нотлох баримтын бүрдээгүй байдал, гүйцэтгэлийн хангалтгүй түвшин зэргээс шалтгаалан үнэлгээний үр дүн буурч байгааг анхааралтай авч үзэх шаардлагатай байна.

Тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийн явцад тулгамдаж буй нийтлэг асуудлуудад:

-тендерийн үр дүнгүй дахин зарлах байдал,

-бэлтгэл ажлын шат дамжлага олон байх,

-суурь судалгааны хугацаа уртдах,

-олон улсын хамтын ажиллагаа болон гэрээ хэлцлийн явц удаашрах зэрэг саад учруулж байна.

Түүнчлэн дээрх тэргүүлэх чиглэл болон Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд ахицтай хэрэгжсэн хэд хэдэн зорилтууд байгааг үүгээр онцолж байна. Үүнд:

1.3.2.6: Зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулж, e-business.mn системд нэгтгэсэн нь хүнд суртлыг бууруулахад бодит ахиц гаргасан.

1.5.2.8: Apple Pay үйлчилгээний нэвтрүүлэлт, TEMU платформын Монголд орж ирсэн байдал нь олон улсын цахим төлбөр, худалдааг дэмжсэн чухал алхам болсон.

4.1.2.8: "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн суурь судалгаа, хэлэлцүүлэг өрнөж, 70 хувийн гүйцэтгэлд хүрсэн.

4.6.3.2: Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний судалгаа, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүн хүлээгдэж байгаа.

Хэрэгжилт хангалтгүй буюу үр дүнгүй хэд хэдэн зорилтууд байна. Үүнд:

1.5.2.6: Шинжлэх ухааны виртуал парк байгуулах төслийн хэрэгжилт зөвхөн ТЭЗҮ, судалгааны шатанд байгаа.

1.5.2.7: Орон зайн цахим дэд бүтцийн бүтээн байгуулалт эхлээгүй, зөвхөн стратеги боловсруулж байгаа нь хэрэгжилт хангалтгүйг илтгэж байна.

4.1.7: Хиймэл оюунаар бүтээгдсэн контентыг таних систем "төлөвлөж байгаа" түвшинд байгаа бөгөөд нотлох баримт ирүүлээгүй тул 0 хувиар үнэлэгдсэн.

4.1.2.5, 4.1.2.6: Аймгуудын цахим шилжилт, харилцаа холбооны хүртээмжийн төсөл хэрэгжээгүй буюу хэмжих шалгуур буруу тогтоогдсон.

4.1.2.2, 4.1.2.1: Хиймэл дагуулын төсөл, нотариатын цахимжилтын төсөл нь төлөвлөгөөний шатанд байна. Гүйцэтгэл нотлогдоогүй, баримт хавсаргаагүй гэх зэрэг асуудлууд байна.

Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах төсөл, арга хэмжээний талаарх төлөвлөлтийг улсын төсвөөс хөрөнгийн эх үүсвэрээ тогтоохоор хүргүүлсэн гэх боловч, зарцуулсан хөрөнгийн эх үүсвэрийн талаарх тайлан ирүүлээгүй байна.

Мөн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүд оновчгүй, хэмжих нэгжийг буруу тодорхойлсон, төсөв шаардагдах ажлын суурь судалгааны баримт байхгүй, тайлагналт дутуу байна. Тодруулбал төлөвлөгөөний дагуу гарсан үр дүнгийн тайланг ирүүлэх байтал буруу шалгуур үзүүлэлтийн улмаас тайлагналт үр дүнрүү чиглээгүй зөвхөн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнажээ.

*Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийн асуудал*

Зарим зорилтод тавьсан шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж нь төслийн бодит хэрэгжилтийг илтгэхэд хангалтгүй, үндэслэлгүй, тухайн төслийн үр дүнг үнэлэхэд тохиромжгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Жишээлбэл:

4.1.2.5 болон 4.1.2.6 зорилтуудад газар сонгосон эсвэл ажлын даалгавар боловсруулсан зэрэг нь шалгуурын дагуу "гүйцэтгэл" гэж тооцогдохгүй.

Зарим тайлан "төлөвлөсөн" гэж дурдсан болович үнэлгээний шалгуур, нотлох баримт хавсаргаагүй нь журмын шаардлага хангахгүй асуудлууд байна.

Иймээс яамны зүгээс илгээгддэг төлөвлөлтийн баримт бичгүүдийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад журамд нийцүүлсэн эсэх талаар нэгжийн удирдлагууд сайтар хянах шаардлагатай байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 3 дугаар хавсралтын хувьд тус яамнаас хариуцан хэрэгжүүлж буй "4.1.2. Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулах" зорилтын хүрээнд хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Хэрэгжилтийг илэрхийлэх таван шалгуур үзүүлэлтийн дундаж гүйцэтгэл 14 хувь байгаа нь уг зорилтын хүрээнд бодитоор гүйцэтгэсэн ажлын хэмжээ хязгаарлагдмал, ажлын явц удаашралтай байгааг харуулж байна. Тухайлбал:

-Шинээр байгуулах серверийн тоо, арга хэмжээний хэрэгжилт зэрэг шалгуур үзүүлэлтүүд огт эхлээгүй, 0 хувийн гүйцэтгэлтэй байна.

-Төслийн хэрэгжилт 10 хувьтай байгаа нь үндэсний стратеги батлагдаагүйтэй холбоотойгоор дараагийн үе шатны ажлууд хойшлогдож буйг илтгэж байна.

Үүрэн холбооны сүлжээний болон сэлгэн ажиллах дэд төвийн ажлуудыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байгаа болович ихэнх нь тендерийн гэрээний шатанд, зарим нь ашиглалтад оруулах шатандаа явж буй тул төлөвлөгөөт гүйцэтгэлийн түвшинд хараахан хүрээгүй байна.

Иймээс нөхцөл байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг бэлтгэлээ.

## Тав.Цаашид авч хэрэгжүүлэх зөвлөмж

Иймд хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх, цаг хугацааны төлөвлөлтийг нарийвчлах, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх нь чухал байна. Үүний зэрэгцээ, анхан шатны бэлтгэл ажил гүйцэтгэлийн үнэлгээнд хангалттай тусгагдаж чадахгүй байгаа тул шат бүрт бодит ахиц, үр нөлөө бий болгох чиглэлээр үр дүнд чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байх тул дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Төлөвлөлтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бэлтгэх;
2. Хэрэгжилт эхлээгүй шалгуур үзүүлэлтүүдэд онцгой анхаарал хандуулж, хариуцлага хүлээх нэгж, албан тушаалтныг тодорхойлох;
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу бэлтгэсэн төлөвлөгөөний төслийг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас саналыг авч холбогдох байгууллагад хүргүүлж байх;
4. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах;
5. Төлөвлөгөөний биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах;

6. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшний тоон үзүүлэлтийг болон чанарыг харгалзан, хүрсэн үр дүн Монгол Улсад ямар эерэг өөрчлөлт оруулсан талаар оруулж байх;

7. Төлөвлөгөөнд туссан боловч салбарын бусад байгууллагаас хамаарах ажилд анхаарал хандуулж, хамтран ажиллах;

8. Төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг тооцоо судалгаатай, баталгаатай хэмжигдэхүйц байдлаар төлөвлөж, санхүүжилт тавигдах эсэхийг урьдчилан тооцож хэвших;

9. Стратеги баримт бичгүүдийн баталгаа, шийдвэр гаргалтын хугацааг хурдасгах, бодлого хэрэгжүүлэгч болон шийдвэр гаргагч талуудын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй болно.

-оОо-

## Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн биелэлт

МУЗГ-ын 35 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

| Д/д | Тэргүүлэх чиглэл | Зорилго | Зорилт | Биелэлтийн хувь | Биелэлт | Тэргүүлэх чиглэлийн дундаж | Зорилгын дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна. | 1.3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд: | 1.3.2.6. Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан хүний оролцоо, хүнд суртлыг арилгана. | 90% | Зөвшөөрлийн тухай хуулиар батлагдсан 178 тусгай зөвшөөрөл, 66 энгийн зөвшөөрөл нийт 244 зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем "e-Mongolia"-ийн дэд суваг болох "e-business.mn"-д нэгтгэсэн. https://e-business.mn/home | 90 | 90 |
| 2 | | | 1.5.2.1 Үндэсний хиймэл дагуул бүтээх, хөөргөх бэлтгэл ажлыг хангана. | 50% | Бүгд найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани ЦХИХХЯ хооронд байгуулах "Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах" арилжааны гэрээний нөхцөлийг сайжруулах, гэрээний үнийн дүнг бууруулах, гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр Талес Алениа Спейс компанитай хамтран ажиллаж байна. | | |
| 3 | | | 1.5.2.2. Нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ. | 30% | Монгол Улсын Шинжлэх ухааны академи, "Жэй Эс инженеринг" компани, Хятадын Цагаан хэрмийн аж үйлдвэрийн корпораци, Зураглал, ажиглалтын технологийн компани, Сансрын технологийн академи зэрэг байгууллага хамтран "Үндэсний зайнаас тандан судлал болон нам орбитын хиймэл дагуул" сэдэвт хурлыг 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Хурлын нээлтэд Монгол Улсын Сансрын бодлогын үндэсний зөвлөлийн дарга, УИХ болон Засгийн газрын гишүүн, ЗГХЭГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч Н. Учрал оролцсон.<br>https://gogo.mn/r/ljeew8 | | |
| 4 | | | 1.5.2.3. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын газрын станц байгуулна. | 0% | Арилжааны гэрээ эцэслэгдээгүй байгаа тул харилцаа холбооны хиймэл дагуулын газрын станцын ажил эхлээгүй байна. | | |
| 5 | | 1.5.2. Хиймэл оюун | 1.5.2.4. Дрон ашиглалтын талаарх эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах ажлыг эхлүүлнэ. | 30% | Тус яамны сайдын 2025 оны А/49 дүгээр тушаалаар "Дроны ашиглалт, хэрэглээний талаар судалж, хууль эрх зүйн орчны судалгаа хийж санал боловсруулах" ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан Уг хурлаар тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах" ажлын даалгаврын төслийг танилцуулан, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэж, батлуулсан, Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулж тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зарласан боловч амжилтгүй болсон тул дахин 2 дахь удаагаа 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарлан 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр нээн ирүүлсэн тендерийг хянан үзэж байна.<br>МУЗГ-ын 209 дүгээр тогтоолын дагуу ГЗБГЗЗЕГ-аас 2025 оны 1/381 албан тоотоор ирүүлсэн байршлуудыг Харилцаа холбооны зохицуулах хороонд радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилтийг хийлгүүлсэн бөгөөд эдгээр байршлуудыг судлахад Баянзүрх дүүргийн байршил нь намагтай, дэд бүтцээс 5км зайтай, Дархан-Уул аймгийн байршил нь Атарын 4-р аяны талбайтай давхцуулж түр хугацаанд ашиглах боломжтой байгаа нь шаардлага хангахгүй тул нарийвчилсан шаардлагыг боловсруулан 2025 оны 02/239 дугаартай албан бичгийг ГЗБГЗЗГ-т дахин хүргүүлж, 2025 оны 1/2182 албан тоотоор Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 1 га газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас СХД-ээс 15.27 га бүхий, БЗД-ээс 9.95 га болон 0.352 га, БНД-ээс 10 га газруудыг дроны туршилтын талбай байгуулах боломжтой саналыг хүлээн авч давтамжийн хэмжилтийг хийлгэхээр ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 1.5. Шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлнэ. | ухаан, мэдээллийн технологийн үндэсний дэд бүтцийг хөгжүүлж, дижитал шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд: | 1.5.2.5. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах ажлыг эхлүүлнэ. | 30% | "Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформыг хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулан, батлуулсан.<br>Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/190 дугаар тушаалаар байгуулж, тендерийг 2025 оны 6 дугаар сарын 13-нд зарласан бөгөөд 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр нээнэ." | 28.75 | 28.75 |
| 7 | | | 1.5.2.6. Шинжлэх ухааны виртуал парк байгуулах төслийг хэрэгжүүлнэ. | 0% | Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төсөл гүйцэтгэх" ажлыг хийж байна. Монгол Улсын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцэх хувилбаруудыг гаргах зорилгоор Matching fund буюу төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн загвар зэрэг боломжит хувилбаруудыг судалж, тэдгээрийн давуу тал, сул тал, хэрэгжих боломжийг шинжилсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн, цаашид хэрэгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулна. Мөн Япон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран Startup Ecosystem судалгааг хэрэгжүүлж байна. | | |
| 8 | | | 1.5.2.7 Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, газар зүйн мэдээллийн систем, блокчэйн технологийг ашиглан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, хөгжлийн бодлого боловсруулах орон зайн цахим дэд бүтцийг байгуулна. | 0% | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Мөн их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн. Дээрх суурь судалгаанд үндэслэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг төслийг 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан, стратегийн төслийн талаарх танилцуулгыг нийт 8 удаагийн хэлэлцүүлэгт танилцуулан хэлэлцүүлсэн. Үүний дараагаар Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, газар зүйн мэдээллийн систем, блокчэйн технологийг ашиглан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан, хөгжлийн бодлого боловсруулах орон зайн цахим дэд бүтцийг байгуулах ажиллагаа хийгдэнэ | | |
